

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

БИЗНЕСИЙН ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ /Анхдагч хууль/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэн, хуулийн этгээдийн бизнесийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг баталгаажуулах, төрөөс бизнесийн үйл ажиллагаанд үзүүлэх дарамтыг багасгах, шударга өрсөлдөөнийг дэмжих, бизнесийн орчны тогтвортой байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Бизнесийн эрх чөлөөний хууль тогтоомж

2.1.Бизнесийн эрх чөлөөний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжоос бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл.Бизнесийн эрх чөлөөг хангах талаар баримтлах зарчим

3.1.Төр бизнесийн эрх чөлөөг хангах талаар дараах зарчмыг үйл ажиллагаандаа дагаж мөрдөнө:

3.1.1.хуулиар хориглосноос бусад бизнесийн үйл ажиллагааг чөлөөтэй эрхлэх нөхцөлийг бүрдүүлэх;

3.1.2.бизнесийн үйл ажиллагаанд хийх төрийн зохицуулалт нь хуульд үндэслэсэн, зайлшгүй, шударга өрсөлдөөнийг хязгаарлахгүй байх;

3.1.3.бизнесийн үйл ажиллагаанд хийх төрийн зохицуулалтын тогтвортой, урьдчилан таамаглах боломжтой байдлыг хангах;

3.1.4.бизнес эрхлэгчийг өмчийн хэлбэр, хөрөнгө оруулалтын эх үүсвэр, байршил, хэмжээ, салбар, хэлбэрээр ялгаварлан гадуурхахгүй хандах;

3.1.5.төрийн үйлчилгээ цахим, ил тод, түргэн шуурхай, тэгш хүртээмжтэй, бизнес эрхлэгчээс мэдээллийг нэг удаа авах нөхцөлийг бүрдүүлсэн байх;

3.1.6.бизнесийн үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээнд суурилсан, давхардалгүй, ил тод, урьдчилан сэргийлэх, зөвлөн туслахад чиглэсэн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх;

3.1.7. иргэн, хуулийн этгээдийн үр ашигтайгаар хэрэгжүүлэх боломжтой бизнесийн үйл ажиллагааг төр эрхлэхгүй байх;

3.1.8.хуульд зааснаас бусад тохиолдолд үнэ тогтоох үйл ажиллагаанд төр аливаа хэлбэрээр оролцохгүй байх;

3.1.9.хууль тогтоомж хооронд давхардал, зөрчил үүссэн тохиолдолд бизнес эрхлэгчид илүү таатай нөхцөл олгосон зохицуулалтыг баримтлах;

3.1.10.төрийн аливаа сонгон шалгаруулах үйл ажиллагаа, төсвийн болон төсвийн бус хөрөнгийн захиран зарцуулалтын хэмжээ, хамрах хүрээ, арга хэлбэр нь бизнес эрхлэгчийн зах зээлд чөлөөтэй, шударга өрсөлдөх боломжийг бүрдүүлсэн байх;

3.1.11.бизнесийн үйл ажиллагааг зохицуулж байгаа хууль тогтоомж, захиргааны шийдвэрийн үр дагаварт жил тутам шинжилгээ хийж шаардлагагүй, давхардсан, үр ашиггүй зохицуулалтыг багасгах.

3.2.Төрийн байгууллага, албан тушаалтан бизнесийн үйл ажиллагаанд хийх төрийн зохицуулалтыг боловсруулахдаа бизнес эрхлэгчид үзүүлэх ачаалал, шударга өрсөлдөөний хязгаарлалт, хөрөнгө оруулалтын орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлж, бизнес эрхлэгч, мэргэжлийн холбоо, иргэний нийгмийн байгууллага, олон нийтийн оролцоог хангана.

3.3.Төрийн байгууллага, албан тушаалтан бизнесийн үйл ажиллагаанд дагаж мөрдөж байгаа төрийн зохицуулалтын үндэслэл, зорилго, үр нөлөөний талаарх мэдээллийг нийтэд ил тод мэдээлж ажиллана.

3.4.Бизнес эрхлэгчийн ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлөх, зардлыг нэмэгдүүлэх хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын дагаж мөрдөж эхлэх хугацаа батлагдсанаас хойш 12-оос доошгүй сарын хугацаатай байна.

4 дүгээр зүйл.Төрийн бодлого, үйл ажиллагаанд хориглох зүйл

4.1.Үндэсний аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхол, шударга өрсөлдөөнийг хамгаалахаас бусад тохиолдолд бизнесийн эрх чөлөөг хязгаарласан, хориглосон хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, дүрэм, журам, норм, стандартын баримт бичиг батлан гаргахыг хориглоно.

4.2.Бизнес эрхлэгчийн нэр хүндэд халдсан үндэслэлгүй мэдээлэл гаргах, түгээхийг хориглоно.

4.3.Бизнес эрхлэгчийг нийгмийн хариуцлагын үйл ажиллагаанд албадан оролцуулахыг хориглоно.

4.4.Хуульд зааснаас бусад тохиолдолд зарим бизнес эрхлэгчид давуу эрх олгосон захиргааны хэм хэмжээний акт, дүрэм, журам батлах, үйл ажиллагаа явуулах, эс үйлдэхгүйг хориглоно.

4.4.Хуульд зааснаас бусад тохиолдолд зарим бизнес эрхлэгчид давуу эрх олгосон захиргааны хэм хэмжээний акт, дүрэм, журам батлах, үйл ажиллагаа явуулах, эс үйлдэхүйг хориглоно.

4.5.Бизнесийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх, оролцох, үндэслэлгүй хяналт шалгалт хийх, өмч хөрөнгийг нь хууль бусаар хураан авах, дайчлахыг хориглоно.

4.6.Бизнес эрхлэгчийн үйл ажиллагаанд хуульд заагаагүй хяналт шалгалт хийх захиргааны шийдвэр гаргах, дүрэм, журам батлахыг хориглоно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

5 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

5.1.Энэ хуулийг зөрчсөн төрийн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

5.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Гарын үсэг